

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

## Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

### 1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 9 дүгээр сард нэг удаа хуралдаж 8 асуудал хэлэлцэн 5 тогтоол баталж 1 тогтоолд өөрчлөлт оруулж мөн нэг тогтоол хүчингүй болголоо. Үүнд:

- Их эрдэмтэн, бичгийн хүмүүн, билгүүн номч Бямбын Ринчений мэндэлсний 110 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх цуврал арга хэмжээний хүрээнд түүний алдар гавьяа, ажил үйлсийг нэр төртэй залгамжлан, их эрдэмтний дурсгалыг мөнхжүүлэх, ирээдүй хойчид сурталчлан таниулах үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Шинжлэх Ухааны гавьяат зүтгэлтэн, Палентлогийн Шинжлэх ухааны доктор, академич Ринчений Барсболдыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

- Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд Монгол Улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дахь заалтыг үндэслэн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 148 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтуудад Сайхан суманд арчилгаа огтлолоор 100 шоо метр, цэвэрлэгээний огтлолоор 400 шоо метр шинэс модыг хэрэглээний зориулалтаар Баруунбүрэн сумын нутгаас бэлтгэхээр тогтоолд өөрчлөлт орууллаа. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцов.

- Ерөө сумын 2 дугаарт багт Христийн шашны “Ерөө Баптист” сүм, мөн сумын 3 дугаар багт Христийн шашны “Бугант Баптист” сүм байгуулж, дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тус тус 3 жилийн хугацаагаар олголоо.

- Эрхэлсэн салбартаа хөдөлмөр бүтээлийн өндөр амжилт гаргасан аймгийн Нэгдсэн эмнэлэгийн их эмч Тогтохын Сэлэнгээг Монгол улсын Гавьяат эмч цолоор, Алтан гадас одонгоор 8, Хөдөлмөрийн хүндэт медалиар 10 иргэнийг тус тус шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

- Сэлэнгэ аймгийн хэмжээнд улс, аймгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалт, засварын ажлуудын талаарх, хичээлийн шинэ жилийн бэлтгэл, намрын ургац хураалтын бэлтгэл ажлын талаарх зэрэг цаг үеийн холбогдолтой мэдээллүүдийг холбогдох хэлтэс, газрын дарга нараас сонслоо.

2015 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжав, зарим Тэргүүлэгчид, Төсөв, эдийн засгийн бодлогын хорооны гишүүд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ч.Дэмбэрэлсайхан, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын мэргэжилтэн нар Сүхбаатар суманд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын явц байдалтай танилцлаа. Тэд Усан бассейны барилгын ажил, төвлөрсөн Худалдааны төвийн барилга, Гурван замын уулзварын тохижилтын ажил, Дулаан дамжуулах төв, Гэр бүлийн ордон, Үерийн далангийн засварын гүйцэтгэл зэрэг 2015 онд Сүхбаатар суманд хийгдэж буй томоохон бүтээн байгуулалтын ажлуудтай газар дээр нь явж гүйцэтгэлийн явц байдалтай нь танилцлаа.

2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжав, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим Тэргүүлэгчид, Хүдэр, Ерөө сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар “Дархан Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн Хүдэр сумын нутагт байрлах “Төмөртэй” уурхайн үйл ажиллагаатай танилцлаа.

## **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 195-р тогтоол, Ерөнхий сайдын 124 дүгээр захирамжийн дагуу “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг” 2015 оны 09 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд тус аймагт зохион байгуулагдаж, нэгдсэн дүнгээр 93.4 хувьтай үнэлэгдлээ. Тус ажлын хүрээнд аймгийн хэмжээнд урьдчилсан үзлэгийг зохион байгуулж, 30 албан байгууллага 17 сум, 6 тосгоны төр төсвийн байгууллагууд хамрагдлаа.

Архангай, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран “Архангай түншлэл 2015” үзэсгэлэн худалдааг Архайнгай аймгийн төв Цэцэрлэг хотод зохион байгуулж, Сүхбаатар, Баруунбүрэн, Түшиг, Ерөө, Шаамар, Мандал, Баянгол, Сант, Орхон сумдын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид 112 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр, 15,8 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Эрдэс баялагийн түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн газар хамтран “Төрийн бүтээмж” сэдэвт сургалтыг 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 25 төрийн албан хаагчийг оролцууллаа.

Авилгалтай тэмцэх газар, аймгийн Засаг даргын Тамгын газар авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдөр сургалт зохион байгууллаа. Авилгын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Албан тушаалтны хувийг ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын хэрэгжилттэй газар дээр нь танилцах, авилгын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, мэдүүлгийн бүрдүүлэлтийн программ хангамж, цахим бүрдүүлэлт, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх зорилгоор энэхүү сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн Х хуралдаан энэ сарын 15-ны өдөр хуралдлаа. Тус хуралдаанаар “Аймаг хөгжүүлэх сан”-аас зээл авах хүсэлтээ ирүүлсэн “Ган Мон Энжелс” ХХК, “Гурван тулгат цамхаг” ХХК, “Алтанбилэг” ХХК-иудын материалуудыг хэлэлцлээ. Хуралдаанаас Цагааннуур, Шаамар, Баянгол, Ерөө сумдад тус бүр 25 айлын орон сууц барьж байгаа “Ган Мон Энжелс” ХХК-д 720 сая төгрөг, Сүхбаатар суманд Канад загварын хаус хороолол барьж байгаа “Гурван тулгат цамхаг” ХХК-д 500 сая төгрөгийн зээлийг ирүүлсэн хүсэлтийн дагуу олгохоор шийдвэрлэлээ. Харин “Алтанбилэг” ХХК-иас ирүүлсэн 300 сая төгрөгийн хүсэлтийг 2016 онд дахин хэлэлцэн шийдвэрлэхээр түр түдгэлзүүллээ.

### **Бусад ажлын талаар:**

#### **1.Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Өмнөговь, Сүхбаатар аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн хамт олон тус хэлтсийн үйл ажиллагаатай танилцан, туршлага солилцон, уулзалт ярилцлага зохион байгууллаа.

Ээлжит баталгаажуулалтын ажлаар Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн, Шаамар, Баянгол, Мандал, Орхонтуул, Сайхан, Сант сумдад ажиллаж, ургац хураалтанд ашиглах авто пүү баталгаажуулах, худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэлээ.

Сүхбаатар, Баянгол, Мандал, Орхонтуул, Сант, Сайхан, Ерөө сумдад ажиллаж, 18 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийснээс 15 аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ олголоо.

Стандартын салбар сангаас 3 аж ахуй нэгжид 23 нэрийн 23 стандартын борлуулалт хийж, 5 аж ахуй нэгж байгууллагад 24 нэрийн 25 стандартаар хангах үйлчилгээ үзүүлээ.

Ургац хураалтын бэлэн байдлыг хангуулах зорилгоор Мандал, Баянгол, Сайхан, Орхонтуул, Сант, Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн, Алтанбулаг сумдад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн 29 автопүүг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа. Зарим аж ахуйн нэгжүүдийн ургацын байдал болон шатахууны зардал хүрэлцээгүйн улмаас Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул, Хушаат сумдын аж ахуйн нэгжүүдийн автожинг баталгаажуулаагүй болно.

Мандал сумын “НИК” ХХК-ийн харьяа шатахуу түгээх станцын 1 түгээгүүрийн хэвийн ажиллагааг шалган, Түнхэл тосгоны “ММБИ” ХХК-ийн шатахуун түгээх газрын дуудлагын дагуу 2 шатахуун түгээгүүрт ээлжит бус баталгаажуулалт хийлээ.

Цахилгаан хэмжих хэрэгсэл баталгаажуулалтаар Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, ДСЦТС ХК-тай хамтран Хүдэр, Ерөө сум, Түнхэл тосгонд ажиллаж 3 фазын 16, 1 фазын 1318 ширхэг цахилгааны тоолуур баталгаажууллаа.

## **2.Мэргэжлийн хяналтын газар:**

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Баянгол, Мандал, Хушаат сумдад ажиллаж хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллан, 96 обьектод хяналт шалгалт, 49 обьектод зөвлөн туслах үйлчилгээг 200 гаруй иргэн албан тушаалтныг хамруулан гүйцэтгэлээ. Нэгдсэн хяналт шалгалтын явцад 161 зөрчлийг ирлүүлж 60 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 2 акт, 21 албан шаардлага, 9 дүгнэлт гаргалаа.

Аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчиг, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран Хүдэр, Ерөө, Баянгол сумдад зохих зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлож буй үйл ажиллагааг таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг 2015 оны 09 дүгээр сарын 05-12-ны өдрүүдэд хэрэгжүүллээ.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Тариалан, хүнсний ногоо тариалагч, үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын 40 гаруй төлөөлөл оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг 2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан.

## **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

8-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	11,222,064.6	8,668,573.1	77.2
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	9,055,409.0	6,571,209.5	72.6
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	16,795,572.2	13,829,986.4	82.3
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	11,202,983.1	8,696,081.3	77.6
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	1,284,147.1	1,069,385.9	83.3
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	378,900.0	159,033.6	42.0
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	620,400.0	331,263.0	53.4
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	2,643,808.4	2,406,741.5	91.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3,776,957.7	3,776,957.7	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	25,668,445.8	25,668,445.8	100.0

	- Ерөнхий боловсролын сургууль	13,368,360.3	13,368,360.3	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	6,454,558.3	6,454,558.3	100.0
	- Эрүүл мэнд, спортын байгууллага	3,513,881.8	3,513,881.8	100.0
	- Соёлын байгууллагуудын	1,951,090.1	1,951,090.1	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	171,320.6	171,320.6	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	209,234.7	209,234.7	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	25,668,445.8	25,668,445.8	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	13,368,360.3	13,368,360.3	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	6,454,558.3	6,454,558.3	100.0
	- Эрүүл мэнд	3,066,053.0	3,066,053.0	100.0
	- Спортын байгууллага	447,828.8	447,828.8	100.0
	- Соёлын байгууллагуудын	1,951,090.1	1,951,090.1	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	171,320.6	171,320.6	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	209,234.7	209,234.7	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	3,348,293.1	3,130,597.5	93.5
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,359,661.3	1,268,463.9	93.3
9	Аймгийн нийт нөөц хөрөнгө гүйцэтгэл	901,982.9	848,447.9	94.1
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	509,300.0	494,632.7	97.1

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2015	2015	2015-VIII
		VII- сар	VIII- сар	2015-VII
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1000	1100	110
	Нарийн боов /кг/	2000	2300	115
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
<b>2</b>	<b>МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	7000	6000	85.7
	Үхрийн мах /кг/	7600	7000	92.1
	Адууны мах /кг/	6000	5500	91.7
	Ямааны мах /кг/	6500	5500	84.6
	Дотор мах, цувдай /цусгүй/	5000	5000	100.0
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	700	800	114
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1000	1000	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	280	280	100
<b>4</b>	<b>Бүх төрлийн өөх тос</b>			

	Ургамлын тос /л/	3400	3400	100
	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100
	Масло /задгай, кг/	5000	5000	100
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	2500	1000	40
	Лууван /кг/	2000	1500	75
	Манжин /кг/	2000	2000	100
	Байцаа /кг/	2000	1000	50
	Сонгино /кг/	2000	1500	75
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
<b>2</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1590	1590	100
	Бензин А - 92	1690	1700	100
	Дизелийн түлш	1830	1830	100

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

#### **1. Архивын талаар:**

“Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг” зохион байгуулагдсантай холбогдуулж, үзлэгийн мөрөөр аймгийн Засаг даргын албан даалгаврыг нийт албан байгууллага болон, сумдын Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг эхлүүлээд байна.

Мөн шалгалтанд хангалтгүй оролцсон Нийгмийн даатгалын хэлтэс, Жавхланта сумын эрүүл мэндийн төв, Орхонтуул сумын эрүүл мэндийн төвийн ажлыг сайжруулах талаар байгууллагын дарга нарт Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Төрийн архивын AMS программд Орхонтуул сангийн аж ахуйн 27 хадгаламжийн нэгжийн 4736 хуудасны мэдээллийн агуулгыг уншиж 4213 заалт, 25745 хүний нэр, 171 байгууллагын нэр, 414 газар зүйн нэрийг шивж орууллаа. Мөн дээрх баримтыг баримтын мэдээлэлтэй холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мастер хувиас Орхонтуул сангийн аж ахуй, нийтийн номын сангийн хөмрөгийн 25 хадгаламжийн нэгжийн 1832 хуудас баримтыг Photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 124, тодорхойлолт 13, магадлагаа 16, цалингийн тодорхойлолт 5 гаргаж үйлчиллээ.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Эрүүл мэнд, хүүхэд залуучуудын талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хууль батлагдсантай холбоотой аймгийн Засаг даргын зөвлөлд Хүүхэд харах үйлчилгээг Сэлэнгэ аймагт нэвтрүүлэх мэдээллийг гаргаж хүргүүллээ.Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой аймгийн өнөөгийн байдлаар улсын төсөвт 33, хувийн хэвшлийн 3, нийт 36 цэцэрлэгт 7394 хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 91,8 хувьтай байгаа хэдий ч 1482 цэцэрлэгийн насны хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна.

Монголын Сурагчдын холбооны сэтгэл судлаач, арга зүйч багш Пагмасүрэнтэй ажил төрлийн уулзалтыг зохион байгуулж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Залуу гэр бүлийг дэмжих, Монгол зан заншлаа эрхэмлэн дээдлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор “Хүндэтгэлийн танхим”-д гэрлэж байгаа 6 хосуудад гэрлэлтийн баталгааг ёслол хүндэтгэлтэйгээр гардуулан өгөх үйл ажиллагааг зохион байгууллаа.

Сум дундын 20-р Шүүхэд нөхцөл байдлын 1 дүгнэлт гарган хүргүүллээ.

## **2. Боловсролынталаар:**

Дэлхийн багш нарын өдрийг угтаж:

- Аймгийн боловсролын байгууллагуудын хамт олноос амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд сэтгэлийн дэм өгөх зорилгоор Төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд “Сайн үйлсийн аян” зохион байгуулж уриалга хүргүүлэн, 2015 оны 09 сарын 28-ны байдлаар 12 байгууллага тус аянд нэгдээд байна.

- “Боловсролын төгөл” байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, “Дэлхийн Зөн” ОУБ, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, “Ой баясах” ХХК зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 1225 ширхэг мод тарьж, 540 гаруй хүн оролцлоо.

2015 оны 08 сарын 31-ээс 09 сарын 08-ны хооронд аймгийн нийт сумдын 1340 ахлах ангийн сурагч болон иргэнд Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний мэдлэгийг олгох сургалт зохион байгууллаа.

2015-2016 оны хичээлийн жилд шинээр нэгдүгээр ангид 77 бүлэгт 2231 сурагч элсэн суралцаж эхэллээ. БСШУЯ-д энэхүү судалгаа болон сургуулийн өмнөх насны алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар санал хүргүүллээ.

Аймгийн “Соёл, урлагийн ажилтны өдөр”-ийг тэмдэглэж, соёл, урлагийн байгууллагын 170 гаруй ажиллагсад “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт сургалтыг аймгийн Боловсрол соёлын газар, Соёл, урлагийн Их сургуультай хамтран зохион байгууллаа.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Энэ онд аймгийн хэмжээнд нийт 196.8 мянган га талбайд тариалалт хийсний 153.0 тн үй ган га талбайд үр тариа, 145.0 мянган га талбайд улаанбуудай, 7632 мянган га-д тэжээлийн ургамал, 36168 мянган га-д тосны ургамал, 2874 мянган га-д төмс, 2170 мянган га-д хүнсний ногооны тариалалт хийсэн. Аймгийн хэмжээнд ургац хураалтын ажил эхэлж энэ сарын 21-ний байдлаар нийт 46894 га талбайгаас 39161 тн үр тариа, үүнээс улаанбуудай 46814 га талбайгаас 39065 тн буюу нэгж талбайгаас 8.3 цн, тосны ургамал 800 га талбайгаас 420 тн буюу нэгжээс 5.5 цн, төмс 1523 га талбайгаас 128 цн буюу 19555 тн, хүнсний ногоо 1234 га талбайгаас нэгжээс 126 цн буюу 15583 тн тус тус хураан аваад байна. Мөн аймгийн хэмжээнд 154170 тн хадлан бэлтгэхээс өнөөдрийн байдлаар 80483 тн хадлан бэлтгээд байна.

Энэ жилийн ургац хураалтанд нийт 498 үр тарианы комбайн, 177 ширхэг ангилангийн жатка, 320 үтрэмийн техник, 90 ширхэг төмс хүнсний ногооны техник ажиллах буюу техникийн хүрэлцээ хангамж урьд жилүүдийн адил хангалттай ургац хураалтын ажлыг 12-18 хоногт хураах хүчин чадлын тооцоо судалгаа гарч техник засвар 83-90 хувьтай байна. Хадлан тэжээл бэлтгэхэд нийт 158 дугуйт трактор, 223 ширхэг 20-25 морины хүчтэй жижиг трактор, 157 ширхэг трактор хадуур, 106 трактор тармуур, 76 хаман боогч 190 морин хадуур, 201 морин тармуур, 463 гар



Инженерийн шугам бүхий бүс газарт гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмшдэг иргэд тус газартаа дулааны шугам татах хүсэлтэй 5 иргэнд шугамын техникийн тодруулга өглөө.

## **2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Жавхлант сумын Эрүүл мэндийн газрын засварын ажлыг “Буурал сутаг”ХХК, Хушаат сумын 0,4кв-н цахилгаан дамжуулах агаарын шугам тоолуур төвлөрүүлэх ажил дууссан боловч техникийн нөхцөлгүй ажил гүйцэтгэсэн тул техникийн нөхцлийг авч шугамыг холбох үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Баянгол сумын хүүхэд хөгжлийн төвийн барилга угсралтын ажлыг “Талхун арал”ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд захиалагчын хяналт хийлээ.

Мандал сумын Тарнийн цэцэрлэгийн өргөтгөлийн ажил, Төрийн орон сууцны корпорацийн гадна шугамын ажил, Хэрх тосгоны цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, Мандал сумын 100 хүүхдийн дотуур байрны 560 хүүхдийн сургуулийн барилгын ажлуудтай үзэж танилцлаа.

Баянгол сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгахаар “Чингисийн төгөл”ХХК гэрээ хийгдсэн бөгөөд тус өдөр гадна ханын өрлөгийн ажил эхэлсэн бөгөөд цутгамал хучилтыг мэргэжлийн байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулахыг тус компаний захирал Батжаргалд үүрэг даалгавар өглөө.

Цагааннуур сумын “Сумын төвийн шинэчлэлт”-ийн ажилд аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хамтран 2015 оны 09-р сарын 23-ны өдөр үзлэг хийлээ.

Баянгол сумын нэргүйн хөндийн уурхайд хийгдсэн зөөврийн Шатахуун түгээх станц, Гүйцэтгэгчээр “Мэш ” ХХК, Шаамарсумын Соёлын төвийн барилга дээр улсын комиссажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээлцүүлсэн.

## **Долоо. Байгаль орчны чиглэлээр**

Хүдэр сумын нутагт ашигт малтмал олборлож хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа болон хууль бус үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагаас усны төлбөр төвлөрүүлэх, хууль бус үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийх, бусад шаардлагатай арга хэмжээ авах зорилгоор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, прокурорын газар, Татварын хэлтэс хамтран хяналт шалгалт хийлээ.

2015 оны 09 дүгээр сар 07-ны өдөр Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа хийх ЖАЙКА олон улсын байгууллагын судалгааны багт аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, бодлого зохион байгуулалт болон тулгамдаж буй асуудлын талаар мэдээ, тайлбар, танилцуулга хийлээ.

## **Найм. Сум орон нутгийн талаар:**

### **1. Алтанбулаг сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2015-2016 оны хичээлийн жилд зориулан Дамбо, Найрамдал цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, эцэг эхчүүдэд зориулан, “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 120 гаруй багш, ажилчид, эцэг эхчүүд хамрагдлаа.

2015 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр, аймгийн Ахмадын хороо, Алтан булаг сумын Ахмадын хороо хамтран Бэлчир бүсийн “Ахмадын дуулах өдөр” дуун цэнгүүний зохион байгуулж, Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар, Орхонтуул, сумдын нийт 110 гаруй ахмадууд хамрагдлаа.



Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газар, Ахмардын хороо хамтран “Ахмадуудаа сонсьё” сарын аяныг зарлан, аяны хүрээнд 2015 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, ахмадууд сүү, цагаан идээ, хүнсний ногоогоор үзэсгэлэн гарганлаа.

Тус сумын нутагт орших Тужийн нарсанд “Юхан кимберлиг” олон улсын байгууллагын төлөөлөгч нараас Ойн нөхөн сэргээлт, Ойд гэрэлтүүлэх огтлолыг хэрхэн хийх талаар, сургалт зохион байгууллаа. Сургалтанд Алтанбулаг сумын нөхөрлөл, аж ахуйн нэгж, Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын захиргааны ажилчид, Сүхбаатар сумын “Ой баясах” ХХК-ийн хамт олон оролцлоо.

## **2.Баруунбүрэн сум:**

Нийтийг хамарсан ажлын хүрээнд Ивэн 1-р багийн нутагт түүх соёлын дургалт зүйлийг хашаажуулан тэмдэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Үүнд Өндөр гэгээн Занабазарын гэрийн буурь, шохой шатааж байсан газар, тоосгоны ам, агуй ам зэрэг газар тэмдэг тэмдэглэгээ хийлээ. Мөн Амарбаясгалант эко эргүүлийн ажлын хүрэн Амарбаясгалант хийдийн ойр орчим болон гол дагуу хог цэвэрлэлээ.

Сумын Засаг даргын 2015 оны А/129 тоот захирамжаар сум хөгжүүлэх сангаас дараах нийт 6 иргэдэд 23.0 сая төгрөгийг 7 ажлын байр бий болгох зориулалтаар олгож байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайд Д.Бурмаа нар тус аймагт ажиллаж аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Х.Даваахүү нар газар тариалангийн үйлдвэрлэлийн явц байдалтай танилцуулан, Баруунбүрэн сумын Хөшөөтөд байрлалтай Ивэн түрүү ХХК, Бүрэн-Оргил Од ХХК-ийн тариан талбайтай танилцаж, тариаланчдын төлөөлөлтэй уулзаж санал сэтгэгдлийг нь сонсож газар тариалангийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар товч танилцууллаа.

Олон нийт-Цагдаа хамтын ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд тус сумын ард иргэдийн дунд санал хүсэлтийн дэвтрийг аялуулан ажиллаж байна. Мөн “Мотоцикль” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, 18 иргэнийг “А” ангилалын жолооны үнэмлэхтэй болгох сургалтанд хамруулаад байна.

## **3.Жавхлант сум:**

Эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн Яамны хөрөнгө оруулалтаар 50,0 сая төгрөгийн дотор их засварын ажил дуусч хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. Оёлант нàдà Эрүүл мэндийн төвд нийт 500 үзэжээ өёёääñýí ýýñ óðüà÷-èèàí ñýðæèèýò 163, àì áóèàòì ðùí үзэжээ 207, èàýâòèòýé õýí àèò 35, áýðèéí èàýâòèòýé үзэжээ 95 өёёääлээ.

Òàòààðùí î ðèí ä 26099.3 ì ýí ääí ò° äð° à î ðî ï ñ 17982.6 ì ýí ääí ò° äð° à î ðæ 68.9 хувèéí àèàèýèòòýé ààéí à. Í ðèí äñí í ýð ò° ðè° ð òýí äýäèèí òòðààì æ 163.5 òòàèèí àèàèýèòòýé áòñàä î ðèí ä òàñàèàèèòàè ààéí à.

Í ðî ï í òòæèéí ò° æèèèéí ñàí æèéí ñàí ò;çæèèò òòàààðèèí ääâóó 41374.5 ì ýí ääí ò° äð° æèè ää÷ 48682.6 ì ýí ääí ò° äð° æèè äýðýýí èé ääâóó ààðàà àæèè çèè÷-èèäýýí èé çàðààèè çàðòòòèèèè.

Сумын Засаг даргын захирамжаар ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажлын хэсэг байгуулагдан газар тариалангийн аж ахуйн нэгж, ногоочдын ургац хураалтын явцын дүн мэдээ авч тариаланч, малчид, ногоочдыг цаг агаарын урьдчилсан мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Урьдчилсан балансаар улаан буудай 5198 тн, төмс 155 тн, хүнсний ногоо 940тн, 40тн малын тэжээл хураан авах төлөвтэй байна. 2015 оны ургац хураалтын явцын мэдээгээр үр тариа 1480 тн ургац, тэжээлийн ургамал 30тн, хадлан 3500тн, төмс 221 тн, хүнсний ногоо 154 тн ургац тус тус хураан аваад байна.

## **4.Зүүнбүрэн сум:**

2016 оны өвөлжилтийн бэлтгэл, сургалтын явц, төсвийн гүйцэтгэл, боловсон хүчний асуудлаар төр төсвийн байгууллагуудын удирдлагуудын зөвлөлдөх уулзалтыг 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж, гарсан зөвлөмжийг төр төсвийн байгууллагуудад хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын “Дөл” тоглолтын нэгдүгээр шатны тоглолтыг сумын ерөнхий боловсролын сургуулиас 2015 оны 09 дүгээр сарын 23-нд зохион байгууллаа.

2015 оны 09 дүгээр сарын 09-23-ны хооронд зохион байгуулсан “Хүүхдийн төлөө сайн үйлсийн аян”-ыг 14-р цэцэрлэгийн хүрээнд “Далайд дусал нэмэр” нэртэйгээр зохион байгуулж, Т.Мөнхзул охинд хичээлийн хэрэгсэл, ариун цэврийн хэрэглэл, хувцас хандивлан сэтгэлийн дэм өглөө.

Тус сумын Эрүүл мэндийн төвөөс 2015-2016 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаатай холбогдуулан ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн дотуур байрны сурагчид болон цэцэрлэгийн насны 160 хүүхдэд цагаан хорхой, шээсний шинжилгээг хийлээ.

#### **5.Мандал сум:**

Залуучууд өөрсдийн дуу хоолойг хүргэж, нийгэмдээ эерэг сайнаар нөлөөлөх, тэдний хөгжил оролцоонд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зорилгоор Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, албан байгууллагуудын 35 хүртэлх насны залуучууд болон 16-аас дээш насны оюутан сурагчдыг хамруулсан “Эрч хүч дүүрэн залуу нас” дэвжээ тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 257 тоот тогтоол, Засаг даргын 2015 оны 497 тоот захирамжийн дагуу тайлант сард иргэдээс хадлангийн талбай ашиглуулах өргөдөл хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгууллаа. Энэ хугацаанд нийт 795 өргөдөл ирсэний 205 буюу 25,7 хувь хадлангийн талбай шинээр олгохыг хүссэн, 590 буюу 74,3 хувь хуучин хадлангийн талбай ашиглаж байснаас, нийт 5548 га талбай хэмжиж 149 га хадлангийн талбай хурааж, 1834,4 га талбайд хадлангийн талбайн зөвшөөрөл олгож ажиллсан. Мөн хураагдсан хадлангийн талбайг засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн хадлангийн газар хүссэн 35 иргэнд олгохоор шийдвэрлэлээ.

Тус сумын нутагт орших Гацууртын ордонд хууль бусаар алт олборлогч иргэдийг сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн байгууллагатай хамтран 3 удаа хяналт шалгалт хийж, 500 иргэн, 40 гаруй тээврийн хэрэгслийг албадан буулгаж, Бороо гоульд ХХК-ийн техникээр 7 чиглэлийн замыг хааж 22 ширхэг цахилгаан үүсгүүр, 28 ширхэг газар ухах багаж зэргийг хураагаад байна.

#### **6.Сант сум:**

Сумын төвийн гэр хорооллуудын хашаа, гудамж талбайг цэгцлэх, өнгө үзэмжийг сайжруулах, нийтийн эзэмшлийн газрыг хамгаалах 60 хоногийн аян зарлаж сумын Засаг даргын 2015 оны А/74 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, аяны хүрээнд “Үлгэр жишээ гудамж” болзолт уралдаан зарлаж, суманд хэрэглээний мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлж буй “Хос төгөл мод” ХХК нь аяны хугацаанд сумын иргэдэд зарим банз модныхоо үнийг хямдруулан худалдаалж байна.

Сумын хэмжээнд ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажил эхэлсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны А/75 тоот захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх цагийн хуваарийг 09 сарын 01-нээс эхлэн 1 сарын хугацаанд богиносголоо.

Сумын ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдалд хяналт тавих орон тооны бус зөвлөл нь 2015 оны

09 дүгээр сарын 17–18–ны өдрүүдэд эрүүл мэндийн төв, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр, сургуулийн дотуур байр, мөн цэцэрлэгийн хүүхдүүдийн хоол хүнсний амт чанар, гал тогоо, анги танхимын ариун цэвэр, хоол хүнсний аюулгүй байдал, агуулах складанд үзлэг шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах талаар байгууллагын удирдлагуудад мэдэгдэл хүргүүллээ.

#### **7.Сайхан сум:**

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хариулга маллагааг сайжруулж, бод малыг өдрийн хариулга, шөнийн манаатай болгох, хулгайн мал, мах худалдан авч бэлтэгчдэд хүлгээлгэх хариуцлагыг чангатгах талаар малчид, мал, мах борлуулагч, бизнес эрхлэгчдийн саналыг сонсож, хамтран ажиллах нөхцлийг бүдүүлэх мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр “Малчдын уулзалт хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллагаас “Олон нийтийн удирдлагат нийтийн ариун цэврийг сайжруулах аргачлал”сэдвээр 2015 оны 09 дүгээр сарын 22-ний өдөр гэр хорооллын 35 өрхийн төлөөллийг хамруулан зохион байгууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Сайхан сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын дулааны шугам болон өвөлжилтийн бэлтгэл ажилд 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр төсвийн байгууллагын дарга эрхлэгч нар хамтран хяналт шалгалт хийлээ.

Тус сумн эмнэлэгээс “Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд тэсвэржилт үүсэхээс сэргийлэхтүхай” стартегийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Антибиотикийг жорын дагуу хэрэглэе” “Антибиотикийн даслаас урьдчилан сэргийлье” сарын аяныг зохион байгууллаа.

#### **8.Сүхбаатар сум:**

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас Ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сумынхаа 8 багийн нийт ахмадуудын дунд явган аялалыг 2015 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгууллаа. Явган аялалд нийт 160 гаруй ахмад оролцон, аялалын үүргэвчний бэлтгэл хангалт, отог засалт, буухиат тэмцээн, оюун сорих тэмцээн зэрэг төрлүүдээр хоорондоо уралдаж нийлбэр дүнгээр н.Навчаа ахлагчтай Ганзам 7-р багийн ахмадын хороо 1 дүгээр байрыг, 2-р байрыг Орхоны 6 дугаар багийн ахмадын хороо, 3 дугаар байрыг Буурхээрийн 8 дугаар багийн ахмадын хороо тус тус эзэллээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Чацаргана, жимс жимсгэнэ тариалагч иргэддээ Чацаргана хураах технологи, талбайн үзүүлэх сургалтыг зохион байгуулж, чацаргана хураах машиныг танилцууллаа. Тус талбайн үзүүлэх сургалтанд жимс жимсгэнэ тариалагч 26 иргэн оролцлоо.

Сумын Тохжилт үйлчилгээний газар нь 2015 оны 09 дүгээр сард 284 дээрхүүд 128501 өй а баууааёу а с° ° í оууауёёуæ áоёæ оёоаалаа.Одоогийн байдлаар орон нутгийн хөгжлийн сангаас нийлүүлсэн КАМА маркийн хоёр машин, DYNA маркийн өөрөө шахагч нэг машин, ЗИЛ-130 2 машин нийт 5 машинаар Сүхбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллага айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэн Төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллаж байна.

#### **9.Хушаат сум:**

Тус сумын "Яргуй" цэцэрлэгт сумын орон нутгийн хөгжлийн сангийн 4.0 сая төгрөгийн санхүүжилтээр гэр цэцэрлэгийн гэр, зөөлөн эдлэл, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоглоомын талбайн шинэчлэл хийгдэж байна.

Тайлант сард нийгмийн даатгалын шимтгэлд 37 байгууллага, аж ахуйн нэгжийн 148929.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 89

хүний 12223.8 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 177 хүний 2016.3 мянган төгрөгийн хураамжийг тус тус оруулаад байна.

Д.Сэнгээгийн нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн хамт олны байгуулсан Д.Сэнгээгийн цогцолборын нээлт болж, нээлтэнд зориулан бөхийн барилдаан, сур харваа, дааганы уралдаан бэсрэг наадмыг зохион байгууллаа.

Монгол улс, ХБНГУ-ын их дээд сургуулийн оюутан солилцооны дагуу ХБНГУ-ын Берлиний чөлөөт их сургуулийн 4-р дамжааны оюутнууд манай суманд “Бог малын эктопаразитууд, хорхойгүйжүүлэх бэлдмэлд Монгол хонины гельминтүүд тэсвэртэй болсныг судлах” судалгааны ажлыг хийж гүйцэтгэх хүрээнд Хушаат сумын цөм сүрэг байгаа Артойлбо, Шугугйт, Бумбан дэв, Намын даваа зэрэг газруудад малчин өрхүүдээр судалгаа хийж малын гадна паразитад үзлэг шинжилгээ хийлээ.

#### **10.Хүдэр сум:**

Тайлант сард сумын Засаг дарга Хадлан, өвс бэлтгэлийн явц байдлын талаар иргэд, малчидтай уулзалт хийлээ. 2015 оны 09 дүгээр сарын 20-ны байдлаар 5600 тн өвс бэлтгээд байна.

Намрын ургац хураалтын ажил эхэлж байгаатай холбогдуулан сумын ургацын комисс байгуулагдан, ургацын штабын жижүүр томилон ажиллаж эхэллээ. 2015 оны 09 дүгээр сарын 20 ны байдлаар 21 га-аас 232тн төмс,улаан буудай 440 га-аас 420 тн, 27 га-аас 188 тн, рапс 100 га-аас 75 тн-ыг тус тус хураан аваад байна.

“Газрын тухай хуулийн дагуу” 2 жил буюу түүнээс дээш жил дараалан ашиглаагүй 85 иргэний 95.3га газрыг хураан авлаа.

#### **11.Орхонтуул сум:**

Тайлант сард “Амьдралын төгөл” нийтийг хамарсан ажил хэрэгжиж нийт 20 иргэн түр ажлын байраар хангагдан өрхийн орлогоо нэмэгдүүлэн ажиллалаа.

Мөн “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 3 өрхийн 3 иргэн “Хадлан тэжээл” нийтийг хамарсан ажилд хамрагдаж хамтран малын хашаа хороо, саравчаа засч янзласан ба өвс тэжээлээ бэлтгэлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургууль хамтран Боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутаг, сургууль, нутгийн удирдлага эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, боловсролын байгууллагын, ололт амжилтыг, сурталчлан таниулахад чиглэгдсэн бага хурлыг зохион байгууллаа. Бага хуралд нийт 40 суралцагч, 45 эцэг, эх 21 багш удирдлага, сум орон нутгийн 3 төлөөлөгч нийт 109 хүн оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2015 оны 05 тоот албан даалгаварын хэрэгжилтийг хангаж малчид, мал бүхий иргэдийн 2015-2016 оны мал өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, өвс хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороогоо засварлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж 9 сарын байдлаар 11000 тн байгалийн хадлан 2,4 тн гар тэжээл бэлтгээд байна.

#### **12.Орхон сум:**

Орхон сумын худалдаа үйлчилгээ эрхлэгчид Архангай аймагт болсон “Архангайн түншлэл-2015”, “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд оролцсон талаарх мэдээлэл, аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн “Миний монгол ТВ”-тэй хамтран зохион байгуулж буй “Иргэдээ сонсьё” шууд нэвтэрүүлгийн хуваарь, онцгой байдлын газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ болон бусад цаг үеийн мэдээ мэдээллүүдийг хүргэх ажлыг зохион байгуулж байна. байна.

Тайлант хугацаанд сумын Засаг даргын Тамгын газраас хууль сурталчилах ажлын хүрээнд Төрийн албаны тухай хуулиар 42 иргэнд, “Нийгмийн халамжийн тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай”, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулиар 36 иргэнд, Газрын тухай хуулиар 21

иргэнд, мөн Татварын хуулиар 39 иргэнд хууль эрхзүйн мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

Сумын Засаг даргын 2015 оны А/105 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж “Ойн цэвэрлэгээ” нийтийг хамарсан ажлыг 2015 оны 08-р сарын 26-ны өдрөөс эхлэн 2015 оны 09-р сарын 02-ныг дуустал 7 хоногийн хугацаанд хийж дуусгалаа. Ойн цэвэрлэгээний ажлыг Хар нүдэн, Таван доржийн ам, Галууны ам, Бүрэгтэй, Шар хөтөл, Мангирт чиглэлд ойн цэвэрлэгээг тус сумын ажил хөдөлмөр эрхэлдэггүй 15 иргэнээр цэвэрлүүлэн нийт 350 га талбайн хуурай, унасан бантсан, унианг идсэн, өмхөрсөн улиас, ширвээ, хус түүж, цэвэрлэгээгээр нийт 45 портер мод бэлтгэлээ.

### **13.Түшиг сум:**

2015 оны 09 дүгээр сарын 22-ны байдлаар тус сумын хэмжээнд ургац хураалт 5.6 хувьтай байна. 3840 тн хадлан бэлтгэж төлөвлөлсөн нөөцөө 100 хувь биелүүллээ.

Ажилгүйдлын бүртгэлд шинээр 11 иргэн бүртгүүлж, “Түшиг индустраль” ХХК-ийн захиалгаар 2 бульдозерчин, 4 туслах ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн захиалгаар 1 үйлчлэгч, хүүхдийн цэцэрлэгийн захиалгаар 1 сахиулын ажилд тус тус зуучлын нийт 8 иргэнийг ажлын байраар хангалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 км сайжруулсан шороон замын ажлыг “Хайвей интернэншл” ХХК 29.5 сая төгрөгөөр, Бохирын машин нийлүүлэх ажлыг “Цахим ертөнц” ХХК 39.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас нийтийн хамарсан “Ой цэвэрлэгээ”-ний ажлыг зохион байгуулж, гарсан гишүү, модыг сумын дэмжлэг туслалцаа шаардлагатай байгаа нийт 30 өрхөд олголоо.

### **14.Шаамар сум:**

Аймгийн Засаг даргын 2015 оны А/361 тоот захирамж, хилийн цэргийн ангиудыг унаажуулах “Нэг багт-Нэг агт, Нэг аж ахуй нэгж, нэг мотоцикл” аяныг хэрэгжүүлж сумын Дэлгэрхаан 1-р баг, Охиндий 2-р багаас тус бүр 1 агт нийт 2 агтыг Хилийн цэргийн 0243 дугаар ангид хүлээлгэн өглөө.

Малыг паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх Угаалганд 9000, туулгалтанд 8000, боловсруулалтанд 10200 нийт 27200 толгой мал угаалга, туулга боловсруултанд хамрагдаж эрүүлжлээ.

Дэлхийн багш нарын баярын өдрийг тохиолдуулан “Хүүхдийн төлөө” сайн үйлсийн аяныг зохион байгуулж сумын хэмжээнд 24 аж ахуйн нэгжбайгууллага, бүл хоршоододуриалгыг хүргүүлж байгууллага хамт олноороо хамтран амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур нийт 26 хүүхдүүдэд бичиг хэрэг, хувцас, оюун ухаан хөгжүүлэх тоглоом зэргээр туслалцаа үзүүлээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР